Хавсралт 6

# САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Байршил | "Санхүүжилтийн хугацаа /оноор/" | "Төсөвт өртөг /сая төг/" | | Гүйцэтгэл/хэрэгжээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Батлагдсан | Шийдвэрлэгдсэн | | |
| ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | |
| Аялал жуулчлал | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Жаргалтхаан сум-Өмнөдэлгэр сум-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр сум-Баян-Адарга сум-Дадал сум чиглэлийн 290 км хатуу хучилттай автозам төсөл | Хэнтий | 2021-2025 | 275,400.00 | 70 км хатуу хучилттай авто замын санхүүжилт шийдэгдсэн | 2022 оны 2-р улиралд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн байх зорилтын хүрээнд “Тэгшт плант” ХХК-тай гэрээг байгуулж зам барилгын ажлыг эхлүүлсэн. Талбайд замын чиг сэргээх, ургамлын үе хуулах, түр зам барих, ухмал байгуулах, зөөврөөр далан байгуулах, хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах, шороон орд нээх ажлууд хийгдсэн. БУА-37.6%-тай. | 30 |
| 2 | Өвөрхангай аймгийн Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн 90.1 км хатуу хучилттай авто зам, Орхон голын 220 у/м төмөр бетон гүүрийг барих төсөл | Өвөрхангай | 2022-2024 | 89,400.00 | 220 у/м төмөр бетон гүүр, 49 км хатуу хучилттай авто замын санхүүжилт шийдэгдсэн | 1.Орхон голын Онгоцтойн амны 220 у/м төмөрбетон гүүрийг 2021 оны 09 сард улсын ашиглалтад оруулсан.<br>2.Хужирт-Бат-Өлзийт чиглэл-ийн 49 км авто замын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан. Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлсэн. БУА 9.2%-тай хэрэгжиж байна. | 70 |
| 3 | Дархан-Эрдэнэтийн автозамаас Амарбаясгалант хийд чиглэлийн 33.2 км хатуу хучилттай автозам төсөл | Орхон | 2022-2024 | 31,200.00 | Шийдвэрлэгдсэн | Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 33.4 км хатуу хучилттай авто зам Засгийн газрын 2017 оны 84 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан. Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто замыг Концесс эзэмшигч: “Пик девелопмент” ХХК.2017 онд ашиглалтад оруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Ханх-Хатгал чиглэлийн замыг барих | Хөвсгөл | 2023-2024 | 161,500.00 | Шийдвэрлэгдээгүй | Ханх-Мондын боомт чиглэлийн 23 км авто зам баригдсан. Харин Цагаан сайрын 73 у/м гүүрийн санхүүжилтийг 2023 оны Улсын төсөвт тусгуулахаар МУ-ын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд саналаа хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Иймээс 2024 оны Улсын төсөвт саналаа дахин хүргүүлнэ. **/Хасуулах саналтай/** | - |
| 5 | Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн замыг барих | Хөвсгөл | 2022-2023 | 30,400.00 | Шийдвэрлэгдсэн | АХБ-ны “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдсэн. Төслийн хэрэгжилтийг БОАЖЯ зохион байгуулж байна. | 100 |
| 6 | Архангай аймгийн Өлзийт - Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл - Мөрөн чиглэлийн аялал жуулчлалын автозам | Архангай, Хөвсгөл | 2022-2023 | 192,804.90 | Шийдвэрлэгдээгүй | Санхүүжилт тодорхой болоогүй | - |
| 7 | Завхан аймгийн Донойн нисэх буудлаас Улаагчины хар нуур хүртэлх 74 км хатуу хучилттай авто зам | Завхан | 2022-2023 | 260,110.00 | Шийдвэрлэгдээгүй | Санхүүжилт тодорхой болоогүй | - |
| 8 | Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл | Увс | 2022-2025 | 61,073.10 | Шийдвэрлэгдээгүй | Концессын зүйлийн жагсаалтад оруулахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд санал хүргүүлсэн. | - |
| Дэд бүтэц: Зам, тээвэр | | | | | | | |
| 9 | Дорнод аймгийн нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох | Дорнод | 2022-2024 | 66,210.00 | Концесс | Концессын зүйлийн жагсаалтад оруулахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд санал хүргүүлсэн. | - |
| 10 | Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын 2 дахь төв байгуулах | Улаанбаатар | 2022-2025 | 98,000.0 | Шийдвэрлэгдээгүй | Санхүүжилт тодорхой болоогүй | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Ховд аймгийн нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох | Ховд | 2022-2024 | 49,900.00 | Концесс | Концессын зүйлийн жагсаалтад оруулахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд санал хүргүүлсэн. | - |
| 12 | Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох | Өмнөговь | 2022-2024 | 300,000.00 | Концесс | Концессын зүйлийн жагсаалтад оруулахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд санал хүргүүлсэн. | - |
| 13 | Улаанбаатар хотын Олон Улсын зорчигчийн төмөр замын төв буудал барих | Улаанбаатар | 2022-2024 | 200,000.00 | Шийдвэрлэгдээгүй | Санхүүжилт тодорхой болоогүй | - |
| 14 | Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл | Сүхбаатар | 2023-2024 | 427,290.00 | Концесс | Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан. Эхний Эрдэнжаргалан-Бичигт хүртэлх 100 км хатуу хучилттай авто замын гэрээ байгуулагдаж эхэлсэн. | 100 |
| 15 | Дорнод аймгийн Хэрлэн сум-Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам төсөл | Дорнод | 2022-2025 | 114,044.90 | Улсын төсвөөр шийдвэрлэсэн | 2022 оны улсын төсөв санхүүжилтийг шийдвэрлэсэн боловч бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан 2023 оны улсын төсөвт нэмэдт санхүүжилт тусгагдсан барилгын ажлыг 2023 онд эхлүүлнэ. | 100 |
| 16 | Дорнод аймгийн Хэрлэн сум-Хавиргын боомт чиглэлийн авто замаас Эрээнцав боомт хүртэлх 160 км хатуу хучилттай авто зам төсөл | Дорнод | 2022-2023 | 152,000.00 | Шийдвэрлэгдээгүй | Санхүүжилт тодорхой болоогүй | - |
| 17 | Дорнод аймгийн Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлэх | Дорнод, Сүхбаатар | 2021-2024 | 2,000,000.00 | Концесс | Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газарт уралдаант шалгаруулалтыг явуулах хүсэлтийг хүргүүлсэн. | - |
| 18 | Дорнод аймгийн Хөөт-Бичигт чиглэлийн | Дорнод | 2023-2024 | 377,000.00 | Концесс | Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан концессын зүйлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 234.1 км төмөр замын төслийг эхлүүлэх | | | | | жагсаалтад тусгагдсан. Уралдаант шалгаруулалтыг зарласан шалгарсан компанитай хэлэлцээ хийгдэж байна. | |
| 19 | Өмнөговь аймгийн Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.5 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх | Өмнөговь | 2023-2024 | 686,000.00 | Концесс | Санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна. Ойрын хугацаанд хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | - |
| 20 | Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төслийг эхлүүлэх | Өмнөговь | 2023-2024 | 377,000.00 | Концесс | Санхүүжилтийг бүрэн шийдвэрлэсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 89%-тай байна. | 100 |
| 21 | Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төв байгуулах төсөл | Улаанбаатар | 2021-2024 | 77,500.00 | Концесс | Улаанбаатар хотын баруун бүсийн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зорилгоор уг төслийг “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д тусган Сангийн яам руу зөвшөөрөл авах тухай албан бичгийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улаанбаатар хөгжлийн корпораци ХК-аас хүргүүлсэн. Зүүн бүсийн тээвэр, логистикийн хувьд нийслэлийн зүгээс 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Туушин ХХК-тай Хамтран ажиллах гэрээг байгуулсан. “Нийслэл хотод ачаа тээврийн логистикийн төвд тавигдах стандарт”-ийг боловсруулах ажлыг Хотын стандартын хяналтын газар, холбогдох байгууллагууд хамтарч зохион байгуулж байна. Улаанбаатар хотын баруун хэсгийн тээвэр, логистикийн төв болох “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд нийслэлийн төсвөөс тус төвийн дэд бүтцийн II дугаар ээлжийн дуусгалын ажлын хөрөнгийг баталж, гүйцэтгэгч сонгон шалгаруулан ажлыг эхлүүлсэн. | 100 |
| 22 | Дорноговь аймгийн Сайншанд сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, | Дорноговь, Өмнөговь | 2022-2024 | 137,610.00 | Шийдвэрлэсэн | Гашуунсухайт боомтод үерийн далан, чингэлэг тээвэр, урт болон богиных тээврийн зам талбайн ажил, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Гурвантэс сумын Шивээхүрэн боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулах | | | | | бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу хийгдэж, жилдээ **10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай уг терминал 2021.09.20-нд ашиглалтад орсон**. | |
| 23 | Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Ховд аймгийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалан, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэлд түшиглэсэн орон нутгийн логистикийн төвүүдийг байгуулах | Сэлэнгэ, Дарха-Уул, Орхон, Өвөрхангай, Ховд | 2022-2024 | 656,500.0 | Гадаадын зээл, тусламж | Зам, тээврийн хөгжлийн яам, Дэлхийн банктай хамтран орон нутгийн эдийн засгийг эргэлтэд оруулахад дэмжлэг болгох зорилгоор логистик, нийлүүлэлтийн сүлжээний платформыг Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд байгуулахаар хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн. Ховд аймагт “Шинэ ховд” төслийн хүрээнд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлээд байна. | 50 |
| НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ | | | | | | | |
| 24 | Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай автозам | Завхан, Говь-Алтай | 2021-2025 | 188,007.60 | Шийдвэрлэгдсэн | Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар, арчлалтын төсөл-3”-ын хүрээнд шийдвэрлэхээр АХБ-тай тохиролцсон. АХБ-ны холбогдох журмын дагуу төсөлд бэлтгэх Техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр зөвлөхийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг АХБ-нд хэрэгжүүлж байна. | 100 |
| 25 | Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай автозам | Ховд, Увс | 2022-2023 | 156,103.28 | Шийдвэрлэгдсэн | Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар, арчлалтын төсөл-3”-ын хүрээнд шийдвэрлэхээр АХБ-тай тохиролцсон. АХБ-ны холбогдох журмын дагуу төсөлд бэлтгэх Техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр зөвлөхийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг АХБ-нд хэрэгжүүлж байна | 100 |
| 26 | Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замын төсөл | Өвөрхангай | 2022-2023 | 53,760.00 | Шийдвэрлэгдсэн | Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар, арчлалтын төсөл”-ийн хүрээнд хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдсэн. Зам барилгын ажил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2021.05.20-ны өдрөөс эхэлж, ашиглалтад хүлээн авсан. | |
| 27 | Булган аймгийн Гурванбулаг-Хишиг-Өндөр-Орхон чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто зам | Булган | 2022-2024 | 82,500.00 | 31 км авто замын шийдвэрлэгдсэн | Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хавсралтад Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 31.08 км /Булган, Хишиг-Өндөр сум/ ажлын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдэж, барилгын ажил гүйцэтгэж байна. Хэрэгжилт 6%-тай. Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын төгсгөл 67.8 км авто замыг 2023 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд санал тусган Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсвийн саналаас хасагдаж батлагдсан. | 30 |
| 28 | Өмнөговь аймгийн Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 220 км хатуу хучилттай авто замын төсөл | Өмнөговь | 2022-2024 | 229,900.00 | Шийдвэрлэгдээгүй | Шийдвэрлэгдээгүй<br>МУ-ын 2022 оны төсвийн тухай хуульд хөрөнгө тусгагдаагүй. 2023 оны улсын төсвийн тухай хуульд тусгуулахаар саналаа Сангийн яаманд хүргүүлсэн боловч шинэ хөрөнгө оруулалтууд улсын төсөвт тусгагдаагүй. | - |
| 29 | Ховд-Өлгий чиглэлийн автозамаас Ховд, Эрдэнэбүрэн сум хүртэлх, Алтай-Ховд чиглэлийн автозамаас Чандмань сум, Хөшөөтийн уурхай хүртэлх, Мянгад-Дөргөн чиглэлийн автозамаас Дөргөн сум хүртэлх нийт 160 км хатуу хучилттай автозам | Ховд | 2021-2025 | 152,000.00 | Шийдвэрлэгдсэн | -Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сумдыг холбох авто замын барилгын ажлыг АХБ-ны “Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Эрдэнэбүрэн сумыг холбох авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу 2021 оны 11 дүгээр сард эхлүүлсэн. Ховд сумыг холбох авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг ханган Тендерийн баримт бичгийн төслийг АХБ-нд хүргүүлээд байна.<br>-Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлсэн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэхээр Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хавсралтад тусган шийдвэрлэсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг эхлүүлсэн.<br>-Хөшөөтийн уурхай нь Ховд аймгийн Цэцэг сумтэй хатуу хучилттай авто замаар холбогдсон ба Цэцэг сумыг Говь-Алтай-Ховд чиглэлийн А0304 улсын чанартай авто замтай холбох ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг Ховд аймгийн 2022 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Ховд аймгийн Дарви сум нь Алтай-Ховд чиглэлийн А0304 дугаар бүхий улсын чанартай авто зам дагууд байрлаж байгаа ба хатуу хучилттай авто замаар холбогдсон болно. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | "Нутгийн зам" төслийн хүрээнд 45 сумдын төвийг хямд өртөгтэй авто замаар аймгийн төвтэй нь холбох ажлыг эхлүүлэх | Улсын хэмжээнд | 2021-2024 | 960,000.00 | Шийдвэрлэгдсэн | Нутгийн зам төслийн хүрээнд он дамжин нийт 5 сумдын төвийг холбох 155.79 км авто замын төсөл, арга хэмжээ хэрэгжсэн. Үүнд: Архангай аймгийн Өндөр-Улаан сумыг холбох 7 км авто зам 56%, Хөвсгөл аймгийн Тариалан сумын холбох 6.3 км 35.8%, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын төвийг холбох 22.89 км авто зам 100%, Төв аймгийн Мөнгөнморьт сумыг холбох 60 км авто замын барилгын ажлын явц 72%-ийн гүйцэтгэлтэй он дамжин хэрэгжиж байна. Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг холбох 59.6 км зам барилгын ажил бүрэн дуусаж улсын ашиглалтад оруулсан.<br>Нутгийн зам төслийн хүрээнд 4 сумын төвийн холбох төслийг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр, 10 сумыг холбох авто замын төслийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 10 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зам барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд:<br>Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр /нийт 4 төсөл, арга хэмжээний 89.54 км авто зам/:<br>- Архангай аймгийн Булган сумыг холбох 35 км, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумыг холбох 16 км авто замын төслийг Дэлхий банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн.<br>- Ховд аймгийн Ховд сумыг холбох 18.776 км, Эрдэнэбүрэн сумыг холбох 19.78 км авто замын төслийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, тухайн төслийн гүйцэтгэгчийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /нийт 10 төсөл, арга хэмжээний 566.4 км авто зам/:<br>Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан дараах барилгын ажлыг шинээр эхлүүлсэн.<br>- Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км авто замын 4 багц ажил-5-31%,<br>- Ховд аймгийн Чандмань сумыг холбох 56.9 км авто зам-18.2%,<br>- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумыг холбох 52.5 км-34%, Батноров, Норовлин сумдыг холбох 130 км авто замын 2 багц ажил-52%,<br>- Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумыг холбох 49 км авто зам-6%,<br>- Булган аймгийн Хишиг-Өндөр сумыг холбох 31.08 км авто зам-2%,<br>- Дорнод аймгийн Чойбалсан сумыг холбох 124.5 км авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.<br>Төслийн хэрэгжилт:<br>- Хөнгөвчилсөн хучилттай авто зам барих нийт 19 төсөл, арга хэмжээ-21%<br>- Олон улсын чанартай хатуу хучилттай авто зам барих нийт 5 төсөл, арга хэмжээ-8%<br>Олон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу холбогдох нийт 14 төсөл, арга хэмжээ-50%-тай байна. | |
| | | | | | | | **87.06** |

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ